



ОРХОН АЙМАГ  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 дугаар сарын 19

Дугаар А/08

Жаргалант сум

Ажлын хэсэг томилон ажиллуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3, 35 дугаар зүйлийн 35.1.15 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.2.1, 77.2.2 дахь заалт, 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсгүүдийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал болон Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийн дагуу “Орон сууцыг худалдан борлуулах, түрээслээд өмчлүүлэх журам”-ын төсөлтэй танилцах, дүгнэлт гаргах иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

1. Н.Хадаа

Гишүүд:

2. Ж.Алтантөгс

3. Г.Хангал

4. Ж.Эрдэнэ-Очир

5. Т.Лхагвацэрэн

2.Ажлын хэсгийг 2025 оны 02 дугаар сарын 26-ны дотор журмын төсөл боловсруулсан Ажлын хэсэгтэй уулзан журамтай танилцан дүгнэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хуралдаанд оруулан хэлэлцүүлж, санал дүгнэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Н.Хадаа)-д даалгасугай.

ДАРГА  Ш.БИЛГҮҮНБААТАР

612500007